



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 507

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлалтай, 12Б магистраль “Амгалан дулааны станц” ХХК-иас дулаан түгээх Тк1250-р цэг хүртэлх 2ф700мм голчтой 4 хос/км дулааны гол шугамын барилга угсралтын ажлын хүрээнд бий болсон нийт 20,322,483,493.00 (хорин тэрбум гурван зуун хорин хоёр сая дөрвөн зуун наян гурван мянга дөрвөн зуун ерэн гурван) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ч.Саранжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б. ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 10 дугаар сарын 30 -ны өдрийн  
50.7 дугаар тогтоолын хавсралт

"Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн  
дансанд бүртгэх барилга байгууламж

Д/д	Хөрөнгийн нэр	Хүчин чадал		Барилга байгууламжийн хугацаа		Захиалагч байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дугаар	Улсын комиссын акт дугаар	Төсөвт өртөг (төгрөг)
		хэм жих нэгж	биет хэмжээ	Эхэлсэн	Дууссан					
1	Баянзүрх дүүргийн 12Б магистраль "Амгалан дулааны станц" ХХК-аас дулаан түгээх Тк1250-р цэг хүртэлх 2ф700мм голчтой 4 хос/км дулааны гол шугам	хос метр	ф700	2014	2015	Эрчим хүчний яам	"Хасу мегаватт" ХХК	С-Д5-5 2014-29	2018.04.04 02/2018	20,322,483,493.00
<b>Нийт дүн</b>										
<b>20,322,483,493.00 (хорин тэрбум гурван зуун хорин хоёр сая дөрвөн зуун наян гурван мянга дөрвөн зуун ерэн гурван)</b>										